

МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

Уучлалын гайхамшиг

Далын ахлагч Жүи-Чанг Жуан

Намайг бага байхад аав маань ахтайгаа муудалцаж билээ. Аав ихэд гомдсон тул ахтайгаа бүрмөсөн харилцаагаа тасалж, биднийг ч бас тэднийд зочилж байхыг хориглосон юм. Нэлээн хожим нь ээжийг хүндээр өвдөж, үхлүүт байхад л аав маань ахыгаа эхнэртэйгээ хамт манайд ирэхийг нь зөвшөөрөв.

Үрэлгэн хүү



ЗУРГИЙГ КЛАРК КЕЛЛИ ГРАИС © IRI

Би дунд сургуульд байхдаа хөрш найзтайгаа маргалдсаныхаа улмаас түүнтэй ярихаа больж, түүнийг “шийтгэхийн” тулд бүх харилцаагаа тасалсан юм. Нэгэн өдөр сүмийн нэг гишүүн түүнийг сүмд дагуулж ирсэн байсан бөгөөд би түүнийг харсан ч үргэлжлүүлэн “шийтгэхийн” тулд ярилцахаас татгалзсан юмдаг. Тэр үед гаргаж байсан зан авир маань одоо надад маш муухай санагддаг. Би түүнийг олж уулзаад уучлаарай гэж хэлэхийг ямар их хүсдэг гээч!

Их Эзэн “ах дүүгийнхээ зөрчлийг үл уучилдаг тэрээр Их Эзэний өмнө буруушаагдахаар зогсох буюу; учир нь түүнд илүү их нүгэл үлддэг болой”¹ хэмээн хэлжээ. Би бага байхдаа уг шүлгийн утгыг ойлгож чадаагүй юм. Би хохирогч болсон атал яагаад намайг гомдоосон хүнийг уучлаагүйн төлөө илүү их нүгэлтэй үлддэг билээ гэж гайхдаг байв. Энэ нь шударга гэж үү? Гэтэл би ердөө л ойлгоогүй байжээ!

Би өсч, том болох тусам туршлага суун, уг судрыг илүү их ойлгохыг хичээснээр эцэст нь “ойлгож авсан юм”! Бурхан бидэнд маш их хайртай учраас ингэж хэлсэн юм байна! Гомдох нь үнэхээр зүрх шимшрэх зүйл боловч хэрэв



Далын ахлагч Жүи-Чанг Жуан

бид, биднийг гомдоосон хүмүүсийг уучлахгүй бол өөрсдөө илүү гүнзгий, илүү удаан шаналах болно. Хайраар дүүрэн Тэнгэрлэг Эцэг маань “Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана”² хэмээн шударга ёсыг Өөрт нь даатгаж орхиосой хэмээн хүсдэг. Ийн үйлдсэнээр бид өөрсдийнхөө сүнсийг гэмтээх үед үүнийг дагалдан ирэх хохирлыг амсахгүй байж чадна.

Энэ зарчмыг ойлгосон нэгэн ухаалаг эгч “Та нар бусдыг уучилснаар зөвхөн өөртөө л энэрэнгүй хандаж байгаа хэрэг юм” гэж хэлсэн байдаг.

Ерөнхийлөгч Бригам Янг мөн дараах жишээгээр уг зарчмыг тайлбарладаг. Хүн хорт могойд хатгуулсныхаа дараа үзүүртэй мод олоод могойг үхтэл цохих гэж хичээдэг нь хамгийн нийтлэг тохиолддог явдал юм. Гэтэл хийх ёстой зөв зүйл нь тусламж авахаар эмнэлэг рүү тэр даруй явах явдал билээ.³ Өөрөөр хэлбэл бид гомдсон үедээ (хорт могойд хазуулахдаа) уучлах сонголтыг хийх нь (цусны ийлдэс хийлгэх нь) өшөө авахаас илүү чухал бөгөөд шалавхан хийх ёстой зүйл юм.

Би бага байхдаа ерөнхийлөгч Спэнсэр В.Кимбаллын *Miracles of Forgiveness* (Өршөөлийн гайхамшиг) хэмээх номыг унших боломжтой байсандаа талархдаг. Би энэ номноос “өршөөлд хязгаар байхгүй”⁴-г сурсан юм. Мөн бид “Бурханы хүчтэй байж, хүн бүрийг, бүр өөрийгөө ч гэсэн уучилж чадна”⁵ гэдгийг сурсан.

Христ бол төгс үлгэр жишээ. Тэрээр мөнх бус үйлчлэлийнхээ үеэр уг сайн мэдээний зарчмыг үг, үйлдлээрээ байнга тайлбарлаж байсан. Тэрээр загалмай дээр өргөгдөж байхдаа хүртэл “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаага мэдэхгүй байна”⁶ хэмээн хэлсэн билээ. Бурхан шударга ёсны шаардлагыг хангахын тулд Өөрийнхөө хайрт Хүүг бидний нүглийг цагаатгуулахаар илгээсэн бөгөөд Тэрээр бидэнд маш их хайртай



гэдгийг би гэрчилж байна. Тэр биднийг дотоод сэтгэлдээ амар амгалан байж амьдраасай гэж хүсдэг. Тэр бидний зүрх сэтгэлд ямар ч “хор” бүү үлдээсэй гэж хүсдэг. Уучлалын гайхамшигаар дамжуулан бид Христийн жинхэнэ шавь болж чадна гэдэгт би бат итгэдэг. Энэ нь бошиглогч Иосеф Смит Картейж шорон руу явахаасаа өмнө “Би зуны өглөө лугаа тайван байна; Бурханд, мөн бүх хүмүүнд хүний мөсөөр гэм зэмгүй байхыг үргэлж хичээдэг билээ”⁷ хэмээн хэлсэнтэй яг адил юм.

Ах, эгч нар аа, хэрэв та нарын хэн нэгэнд бусдыг уучлахад хэцүү байвал “Христийн Цагаатгалын эдгээгч хүч

биднийг өөрсдөө хэзээ ч хийж чадахааргүй зүйлсийг хийхээр хүчирхэгжүүлэх болно”⁸ хэмээн ахлагч Бэднарын хэлснийг санаарай.

Би уг үнэн зарчим Бурханаас ирсэн гэдгийг мэднэ. Бид бүгд үүнийг хийж чадна! ■

ЭШЛЭЛҮҮД

1. Сургаал ба Гэрээ 64:9
2. Сургаал ба Гэрээ 64:10
3. Марион Д.Ханкс, “Forgiveness: The Ultimate Form of Love,” *Ensign*, 1974 оны 1-р сар, хуу 21
4. Спэнсэр В.Кимбалл, *The Miracle of Forgiveness* (1969), хуу 262, 282-ыг үзнэ үү.
5. Спэнсэр В.Кимбалл, *The Miracle of Forgiveness* (1969), хуу 298-300, 339, 344-ийг үзнэ үү.
6. Лук 23:34
7. Сургаал ба Гэрээ 135:4
8. Дэвид А.Бэднар, “In the Strength of the Lord,” *Ensign*, 2004 оны 11-р сар, хуу 77-г үзнэ үү.

Цовдлолт

Бидний бахархал

Дөрөвдүгээр сарын Бригам Янгийн Их Сургуулийн мэдээллийн хуудсанд монголын гэгээнтэн залуусын талаар гарсныг та бүхэнтэй хуваалцахад таатай байна. Та бүхэн <http://newsroom.byuh.edu/node/2798> гэсэн хаягаар орж уг мэдээллийг үзнэ үү. ■



Эхний эгнээнд уг төслийг бидэнд танилцуулсан Хатанбаатар, Энхбат, Соёлмаа, ахлагч Нэй, Нэй эгч, эмнэлгийн дарга Галсанцэдэн ба тус эмнэлгийн ажилтнууд

Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагын үйл ажиллагаанаас

2014 оны 4-р сарын 3-ны өдөр тус байгууллагаас Сонгино Хайрхан дүүргийн Хүүхдийн эмнэлэгт ойролцоогоор 14 сая 580 мянган төгрөгийн өртөг

бүхий хүчилтөрөгчийн гурван аппарат хандивлах ёслолын ажиллагаа боллоо. Уг аппаратуудыг ажиллуулснаар жилд нийт 3600 хүүхдэд тусламж үзүүлэх боломжтой болох юм.



Эмнэлгийн дарга Галсанцэдэн ахлагч Нэйд талархал илэрхийлж байгаа нь

СХД-ийн Хүүхдийн эмнэлэг нь Сонгино хайрхан, Баянгол дүүргүүдийн 0-16 насны хүүхдүүдэд үйлчилдэг бөгөөд эдгээр дүүрэгт 120 мянган хүүхэд амьдардаг. Тус эмнэлэг өдөрт 80-100 өвчтөнд үйлчилдэг ба тэдний тэн хагас нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай байдаг байна. Хүчилтөрөгчийн аппарат нэн шаардлагатай байсан бөгөөд ялангуяа агаарын бохирдол дээд цэгтээ хүрдэг хүйтэн сэрүүн өвлийн улиралд асар их хэрэгцээтэй байдаг. Эдгээр аппарат нь амьсгалын замын элдэв төрлийн хатгаа, амьсгал боогдох астма зэрэг өвчний үеүдэд хүчилтөрөгч шаардах бие махбодуудад асар их дэм өгөх болно. ■

Христийн сайн мэдээ бидний амьдралд

Миний гэрчлэл

Намайг Үүрцайх гэдэг. Би Сансар салбарын залуу эмэгтэй. Сүмийн гишүүн болоод 9 жил болж байна. Би семинарын ангийн талаар гэрчлэхийг хүсч байна. Учир нь би 4 жилийн турш семинарын ангид суралцаж, намайг болоод амьдралыг маань өөрчилсөн олон зүйлийг сурсан.

Жишээлбэл, өглөө босохоос залхуурахтай хэрхэн тэмцэхийг суралцсан. Мөн семинарын ангид суусан өдөр өдөржин аз жаргалтай, гэрэл гэгээтэй байдаг. Гачигдал зовлонтой хүмүүсийг ойлгож, тэдэнд хэрхэн үйлчлэхийг суралцсанаар зан төлөв маань маш их өөрчлөгдсөн. Семинартаа яваагүй үед Сүнс маань нэг шат доошилсныг би мэдэрдэг. Харин семинартаа явах үед зөв сонголт хийж чадна гэдгээ мэдэрдэг. Энэ бүгдийг би Есүс Христийн нэрээр гэрчилж байна, амен. ■



Үүрцайх

Семинар амьдралыг минь өөрчилсөн

Дэлхий даяар Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн 14-17 насны хүүхдүүд өглөө эрт 5 цагт босч, өглөөний семинарт хамрагддаг. Харин би эдгээр хүүхдүүдийн нэг. Намайг Алтаншагай гэдэг бөгөөд 2013 онд семинарын ангийг төгссөн. Гэхдээ номлолд явахаасаа өмнө өөрийгөө илүү сайн бэлдэхийн тулд одоо 5 дахь жилдээ семинарт явж байна.

Анх манай гэр бүл сүмд хөрвүүлэгдэхээс өмнө ээж маань намайг дүү шигээ семинарт яваасай гэж хүссэн юм. Би “Ээж ээ би хичээл ихтэй амжихгүй байх аа. Бас би тийм эрт босож чадахгүй шүү дээ” гэж хэлж билээ. Ээж маань хариуд нь “Миний охин ганц л удаа яваад үз” гэж ятгасан юм. Би дурамжхан зөвшөөрөв. Маргааш нь буюу 2010 оны 1 сарын 15-ны өдрийн өглөө анх удаа семинарт явлаа. Семинарын хичээл эхлэхээс дуусах хүртэл би өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй маш сайхан зүйлийг мэдэрч байлаа. Зүрх минь баяраар дүүрч, биеэр минь цахилгаан мэт зүйл тасралтгүй гүйж байх шиг санагдсан. Анхны энэ хичээлийн дараа би дахиж семинарт үргэлжлүүлэн явахаар шийдлээ. Ингэж явсаар нэг л мэдэхэд 4 жил өнгөрч диплом авсан. Энэ 4 жилийн хугацаанд миний сурлага огцом сайжирч, сургуулийнхаа тэргүүний сурагч болсон. Мөн хамгийн чухал нь манай гэр орон амар амгалан аз жаргалаар үргэлж бялхах болсон юм. Ийм байдлаар



Алтаншагай

Тэнгэрлэг Эцэг судар дээр хэлдэгчлэн адислалыг надад болон манай гэр бүл дээр хальтал асгасан юм.

Мөн түүнчлэн семинар “бид Бурханы зарлигуудыг дагахын хэрээр уг нутагт дэвжих болно” гэсэн энгийн бөгөөд чухал зарчмыг надад заасан бөгөөд энэ нь одоо хүртэл миний амьдралд биелэлээ олсоор байдаг. Жишээ нь: Би сүмдээ идэвхтэй үлдэж мөн номлолд үйлчлэхээр шийдвэрээ гаргаж, Тэнгэрлэг Эцэгийн зам дээр бат зогсож үлдсэн юм.

Хамгийн сонирхолтой нь “ганц л удаа явна шүү ээжээ” гэж хэлсэн үг маань миний амьдралыг бүхэлд нь өөрчилж чадсан бөгөөд семинарын анги руу хөтөлсөн. Энэ бол миний амьдралын хамгийн зөв шийдвэр байсан юм.

Семинарт идэвхтэй явж төгссөн хэн ч алдагдсан хонь болж төөрөхгүй байх болно гэдгийг би гэрчилж байна. Есүс Христийн нэрээр, амен. ■